

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 тоот тушаалын
6 дугаар хавсралт

Тэгш хамран сургалт, хүүхдийн хөгжил хамгаалал, сургалтын орчны бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн, Сөртөөн
Пүрэвсайхан

2024 ОНЫ ХАГАС ЖИЛ-Н ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

НЭГ. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1.1. Сургуулийн өмнөх боловсролын салбарын эрх зүйн орчныг сайжруулах.							
1	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлагын төсөл боловсруулж, батлууна.	Баримт бичиг	Төсөл боловсруулсан.	Шаардлага батлуулсан байна.	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлагын төслийг дараах бүтэцтэйгээр боловсрууллаа. Үүнд: 1. Хамрах хүрээ 2. Норматив ишлэл. 3. Нэр томъёоны тодорхойлолт. 4. Ерөнхий шаардлага. 5. Тусгай шаардлага. 6. Сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай. 7. Хүүхдийн цэцэрлэгийн ном гэсэн 7 агуулгын хүрээнд шалгуурыг боловсрууллаа. " Сургуулийн өмнөх	1-р сар, 2-р сар, 3-р сар	Өөрийн үнэлгээ: 30% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлага"-ын төслийг нийслэлийн БШУГ, дүүргийн БХ-ийн мэргэжилтэн, аймаг, нийслэлийн цэцэрлэгийн багш, арга зүйч, удирдах ажилтнуудын төлөөллөөс санал авч , сайжруулан, яамны харьяа Боловсролын судалгааны хүрээлэнд Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн даргын 2024 оны 5 дугаар сарын 06-ны өдрийн "Санал авах тухай" 16/1847 тоот албан бичгээр хүргүүлэн, ирүүлсэн санал, зөвлөмжийг судлан дахин боловсруулалт хийн ажиллаж байна. Сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгай нь сургалтын хөтөлбөрийн нэг чухал бүрэлдэхүүн хэсэг тул Засгийн газрын 2024 оны 4 дүгээр сарын 24-ний өдрийн "Үзэл баримтлал батлах тухай" 176 дугаар тогтоолоор батлагдсан сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын сургалтын хөтөлбөрийн үзэл	
--	--	--	--	--	---	--

					баримтлал, сургалтын хөтөлбөрийг шинэчлэн боловсруулах, турших, хэрэгжүүлэх, төлөвлөгөөний арга хэмжээтэй "Сургуулийн өмнөх боловсролын сургалтын хэрэглэгдэхүүн, тоглоом наадгайд тавих шаардлага"-ыг уялдуулан ажиллаж байна. Хавсралт: 2 файл		
2	Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын үйлчилгээний стандартын төсөл боловсруулна.	Баримт бичиг	Баримт бичгийн судалгаа хийсэн.	-	Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээний стандартын төслийг боловсруулан ажиллаж байна. Сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд заавал дагаж мөрдөх шаардлага, шалгуурыг эрхлэгч, арга зүйч, багш болон бусад ажилтан, эцэг эх, асран хамгаалагч болон бусад оролцогч талуудын үйл ажиллагаатай холбон боловсруулж байна.	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 30% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
1.3. Сургуулийн өмнөх боловсролын хөтөлбөр, үнэлгээ, хүний нөөц, хүүхдийн хөгжил, хамгааллын бодлогын удирдлага зохицуулалтыг хангах.							
3	Цэцэрлэгийн арга зүйчдийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч,	Сургалтад хамрагдсан арга зүйчийн	Сургалтын модуль боловсруулсан, 25 сургагч багш	-	"Цэцэрлэгийн арга зүйчдийг хүүхэд, эцэг эх, асран хамгаалагч, багш,	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р	Өөрийн үнэлгээ: 50%

	багш, ажилтанд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэргэшүүлэх сургалтыг удирдлага, зохицуулалтаар хангаж ажиллана.	тоо	бэлтгэгдсэн.		ажилтанд сэтгэл зүйн дэмжлэг үзүүлэх мэргэшүүлэх сургалт" -ыг 2023 онд НҮБ -ын Хүүхдийн Сангийн санхүүжилтээр МУИС-ийн Сэтгэл судлалын танхимын багш, сэтгэл зүйч нартай хамтран сургалтын хөтөлбөр, модулийг боловсруулж, Нийслэлийн Баянзүрх дүүргийн цэцэрлэгийн арга зүйч нарыг хамруулсан 3 өдрийн танхимын сургалтыг зохион байгуулж, үндэсний хэмжээнд 25 "Сургагч багш" бэлтгэсэн. Боловсруулсан модулийг дахин сайжруулах, цахим гарын авлага болгох, Сургагч багш нараараа дамжуулан улсын хэмжээнд 930 цэцэрлэгийн арга зүйч нарыг мэргэшүүлэх сургалтад хамруулахаар төлөвлөн, НҮБ-ын Хүүхдийн Санд санхүүжүүлэх хүсэлт илгээсэн боловч, боломжгүй гэсэн хариу ирүүлсэн. Иймд өмнө нь боловсруулсан модулийг сайжруулж, цахим ном болгон үндэсний хэмжээнд түгээн дэлгэрүүлэх,	сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
--	---	-----	--------------	--	--	---	---

					Боловсролын ерөнхий газрын үндсэн сургалтын агуулгад тусгах, модуль сургалт болгох боломж байгаа эсэх талаар судалгаа хийн ажиллаж байна. Хавсралт: 1 файл		
4	“Сургуулийн өмнөх боловсрол ба Цахим технологи” зөвлөлдөх уулзалт	Арга хэмжээ	-	Зөвлөлдөн уулзалт зохион байгуулсан байна.	Монгол Улсын Засгийн газар - НҮБ-ын Хүүхдийн Сангийн 2023-2027 оны хамтарсан Улс орны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024-2025 оны хамтын ажиллагааны төлөвлөгөө 2024.03 сард батлагдсан. 2024 оны 5 дугаар сард НҮБ ын Хүүхдийн санд "Сургуулийн өмнөх боловсрол ба Цахим технологи" зөвлөлдөх уулзалт, форумыг зохион байгуулахад шаардагдах 9,9 сая төгрөгийн санхүүгийн хүсэлтийг хүргүүлсэн ба хариу хүлээгдэж байгаа тул төлөвлөсөн хугацаандаа хийж амжаагүй байна. Хавсралт: 2 файл	3-р сар, 4-р сар	Өөрийн үнэлгээ: 30% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%
5	Цэцэрлэгийн менежментийг сайжруулах зөвлөмж боловсруулан, сургалт, зөвлөн туслах ажлыг зохион	Зөвлөмж, сургалтад хамрагдсан удирдах ажилтны тоо.	-	Цэцэрлэгийн менежментийг сайжруулах зөвлөн туслах ажлыг зохион байгуулсан	Цэцэрлэгийн менежментийг сайжруулах зөвлөмжийн "Хүүхдийн хөгжил, хамгаалал, орчны аюулгүй байдал"	1-р сар, 2-р сар, 3-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын

	байгуулна.			байна.	агуулгын хүрээнд зөвлөмж, сургалтын танилцуулга боловсрууллаа. Зөвлөн туслах ажлын удирдмжийн дагуу Увс /58/, Баян-Өлгий /94/, нийслэлийн Хан-Уул дүүрэг /32/, Баянзүрх дүүрэг /39/-ийн цэцэрлэгүүдийн 223 эрхлэгч, арга зүйчийг хамруулан сургалт зохион байгууллаа. Сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын менежментийг туршин хэрэгжүүлсэн Увс аймгийн 11 дүгээр цэцэрлэг, Баян-Өлгий аймгийн 6 дугаар цэцэрлэг, Хан-уул дүүргийн 65 дугаар цэцэрлэг дээр тус тус ажиллаж, үнэлгээнд суурилсан төлөвлөлт хийх арга зүйн дэмжлэг үзүүлж зөвлөн туслах ажлыг хийлээ. Мөн тус аймаг, дүүргийн нийт 8 цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагаатай танилцан сургалтын хөтөлбөрийн хэрэгжилт, хүчин төгөлдөр үйлчилж буй салбарын эрх зүйн баримт бичгүүдийг уншиж судлах, багш,	үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	------------	--	--	--------	---	--

					ажилтанд танилцуулах, хэрэгжилтийг хангаж ажиллах, (Жишээ нь: Засгийн газрын 2020 оны 91 дүгээр тогтоол, БШУ-ы сайдын А/170, А/164 гэх мэт), цэцэрлэгийн эрхлэгч нарын байгууллагын төсөв, санхүүгийн боловсролын дээшлүүлэх, мэргэжил арга зүйн дэмжлэг үзүүлэх, цэцэрлэгийн Хүүхэд хамгааллын баг, Дэмжлэгийн багийн үйл ажиллагааны талаарх ойлголтын талаар зөвлөгөө өгч ажиллалаа. Хавсралт: 1 файл		
6	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын гадаа тоглоомын талбай, Биеийн тамирын талбайн тоглоомын аюулгүй байдал, өнөөгийн нөхцөл байдал цаашид анхаарах асуудлаара Зөвлөмж боловсруулна.	Баримт бичиг	-	-	Сургуулийн өмнөх боловсролын байгууллагын сургалтын орчны стандартын шалгуур 75 асуултыг өнөөгийн нөхцөл байдалд нийцүүлэн дахин сайжруулах, цэцэрлэгийн гадна тоглоомын талбай, биеийн тамирын талбайг тохижуулах, шинэчлэх талаар ажлын зураглалыг Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн даргад танилцуулж, зөвлөмж чиглэл авч сайжруулалт	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар	Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хийн ажиллаж байна. 2024-2025 оны хичээлийн жил эхлэхээс өмнө буюу 8 дугара сарын 05-нд нийслэлийн Боловсролын газар, аймгийн, Боловсрол, шинжлэх ухааны газарт хүргүүлэхээр төлөвлөж байна. Хавсралт: 1 файл		
1.4. Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээ, төлөвлөгөөний хэрэгжилтийг удирдлага, зохицуулалтаар хангах.							
7	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний хэрэгжилт, зохицуулалтыг ханган ажиллана.	Төлөвлөсөн үйл ажилагааны хэрэгжилт	-	-	Бага насны хүүхдийн цогц хөгжлийг дэмжих арга хэмжээг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний 4 дүгээр Зорилт арга хэмжээний 4.4.-т "Хүүхдийн бие бялдрын өсөлт, хөгжлийг үнэлэх жишиг далгуур үзүүлэлтийг тогтоож, хүүхдийн хөгжлийн үнэлгээг үндэсний түвшинд хийх" хэрэгжүүлэх үйл ажиллагааг чиг үүргийн дагуу Боловсролын судлагааны хүрээлэнд Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн даргын 2024.05.24-ний өдрийн "Бэлтгэл хангаж ажиллах тухай" 16/2193 тоот албан бичгээр	4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар	Өөрийн үнэлгээ: 30% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 50%

					хүргүүлээ. Хавсралт: 1 файл		
1.2. Сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, тэгш хамруулан сургах бодлогын удирдлага зохицуулалтыг хангах.							
8	Сургуулийн өмнөх боловсролын хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллана.	Хамрагдалтын хувь	Малчдын хүүхдийн хамрагдалт 73.8хувь, Хилчдийн хүүхдийн хамрагдалт 75,0 хувь.	-	"Сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах талаар 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г боловсруулан, Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. СӨБХ ийн даргын "Хамтарч ажиллах тухай" 16/1591 тоот албан бичгийг Үндэсний Статистикийн хороонд хүргүүлж, улсын хэмжээнд байгаа 0-6 хүртэлх насны малчин өрхийн хүүхдийн судлагааг хийж, газрын зураг буюу байршлаар төлөвлөлт хийн ажиллаж байна. 2024-2025 оны хичээлийн жилд малчин өрхийн 2-5 насны 51369 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулахаар хичээлийн жилийн бэлтгэл ажлын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					төлөвлөгөөний төсөл боловсруулан ажиллаж байна. (Хавсралтаар оруулсан файлын код 0503) Хууль зүй, дотоод хэргийн сайд, Боловсрол, шинжлэх ухааны сайд, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын А/220, А/269, А/96 дугаар хамтарсан тушаалаар баталсан “Хилчдийн бага насны хүүхдийн хөгжлийг дэмжих сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах талаар 2023-2025 онд авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө”-ний хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа ба энэ хичээлийн жилд хилчдийн бага насны хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах талаар дараах арга хэмжээг авч хэрэгжүүллээ. Үүнд: i) цэцэрлэгийн салбар бүлэг нээх, ii) шинээр гэр цэцэрлэг байгуулах, iii) гэр бүлд суурилсан явуулын сургалтад хамруулах. Үүний үр дүнд 2023-2024 оны хичээлийн жилд 1489 (84,7%) хүүхэд сургуулийн өмнөх	
--	--	--	--	--	--	--

					боловсролын үйлчилгээнд хамрагдаж, хамран сургалт өнгөрсөн хичээлийн жилээс 9,7 хувиар нэмэгдэж, 170 хүүхдийг шинээр нэмж хамрууллаа. ХХЕГ-т 2024-2025 оны хичээлийн жилд өмнөх хичээлийн жилд хийсэн ажлын үр дүнг сайжруулах, тогтвортой байдлыг хангахаас гадна бусад яам, агентлагтай хамтран хэрэгжүүлэх 7 багц арга хэмжээг хэрэгжүүлэх, шаардлагатай бол нэмэлт судалгаа хийж, мэдээлэл солилцон хамтран ажиллах тухай СӨБХ ийн даргын 2024.5.24-ний өдрийн 16/2221 тоот албан бичгийг хүргүүллээ. Хавсралт: 2 файл		
9	Малчдын хүүхдийн хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.	Ажлын гүйцэтгэл	-	Зөвлөмж, боловсруулан , хэрэгжилтийг хангасан байна.	Малчдын хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулах, сургуулийн өмнөх боловсролын хувилбарт сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах, хамрагдалтыг нэмэгдүүлэх арга хэмжээний хүрээнд "Сургуулийн өмнөх	2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа

					боловсролын хувилбарт сургалтын чанар, хүртээмжийг сайжруулах талаар 2023-2024 оны хичээлийн жилд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө"-г Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн даргаар батлуулан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна. Энэхүү төлөвлөгөөнд тусгагдсан 2 арга хэмжээ Монгол Улсын Засгийн газар - НҮБ-ын Хүүхдийн Сангийн 2023-2027 оны хамтарсан Улс орны хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2024-2025 оны хамтын ажиллагааны батлагдсан (2024.03 сард) төлөвлөгөөнд тусгагдсан тул НҮБ-ын Хүүхдийн Санд санхүүгийн хүсэлтийг хүргүүллээ. Сургуулийн өмнөх боловсролын хэлтсийн даргын "Хамтарч ажиллах тухай" 16/1591 тоот албан бичгийг Үндэсний Статистикийн хороонд хүргүүлж, улсын хэмжээнд байгаа 0-6 хүртэлх насны малчин өрхийн хүүхдийн судлагааг хийж, газрын зураг буюу байршлаар төлөвлөлт хийн ажиллаж	гүйцэтгэсэн байдал: 100%
--	--	--	--	--	--	---------------------------------

					байна. Улсын хэмжээнд 189.3 мянган малчин өрхийн 2-5 насны 51369 хүүхдийг 2024-2025 оны хичээлийн жилд сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулахаар хичээлийн жилийн бэлтгэл ажлын төлөвлөгөөний төсөл боловсруулан ажиллаж байна. (Хавсралтаар оруулсан файлын код 0503.) Хавсралт: 2 файл		
10	Сургуулийн өмнөх боловсролын хамран сургалтыг нэмэгдүүлэх, хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ.	Хамрагдалтын хувь (3-5нас, 5 нас)	3-5 настай хүүхдийн хамран сургалт 92,7, Таван настай хүүхдийн хамран сургалт 94,8 хувь	3-5 настай хүүхдийн СӨБ-ын үйлчилгээнд хамрагдалтын хувь 93,5 хувь, 5 настай хүүхдийн хамран сургалтыг 96.5 хувьд хүргэсэн байна.	Улсын хэмжээнд 3-5 насны 230,536 хүүхэд байгаа ба 2023-2024 оны хичээлийн жилд 213,869 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, хамран сургалт 92,8 хувьд хүрч, өмнөх хичээлийн жилээс 2,4 хувиар өссөн байна. Улсын хэмжээнд 5 настай 77,115 хүүхэд байгаагаас 2023-2024 оны хичээлийн жилд 73,085 хүүхэд хамрагдаж, хамран сургалт 94,8 хувьд хүрч, өмнөх хичээлийн жилээс 1,3 хувиар өссөн байна. Мөн Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хуульд 5 настай	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд заавал хамруулахаар хуульчлагдсантай холбоотойгоор улсын хэмжээний таван настай хүүхдийн мөшгих судалгаа хийж, судалгаанд суурилсан төлөвлөлт хийж, хэрэгжүүллээ. Өнгөрсөн хичээлийн жилд 3-5 нас, 5 настай хүүхдийн хамран сургалт улсын дунджаас доогуур 6 аймагт зөвлөмж, чиглэл хүргүүлж, зөвлөн туслах ажлыг зохион байгуулсанаар Баян-Өлгий аймаг /74%/, Булган аймаг /77%/, Дундговь аймаг /76%/, Дорноговь аймаг /76%/, Сэлэнгэ аймаг /78%/, Хөвсгөл аймаг /79%/ зэрэг аймгуудын хамран сургалт 2023-2024 оны хичээлийн жилд 3-10 хувиар нэмэгдсэн байна. Мөн сургуулийн өмнөх боловсролын хамран сургалт улсын дундажаас доогуур байгаа Булган, Дундговь, Хөвсгөл, Баян-Өлгий, Ховд, Завхан аймаг, мөн 5 настай хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд бүрэн хамруулаагүй, хамран	
--	--	--	--	--	--	--

					сургалт доогуур байгаа аймаг, нийслэл, дүүргийн Боловсрол, шинжлэх ухааны газар, Боловсролын газрын дарга нарт шинэ хичээлийн жилд хүртээмжийг нэмэгдүүлэх талаар арга хэмжээ авч ажиллах талаар чиглэл, зөвлөмж хүргүүлэн, 2024-2025 оны хичээлийн жилийн бэлтгэл ажлын төлөвлөгөөнд тусган ажиллаж байна. Хавсралт: 2 файл		
11	Хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрхийн хүүхдийг 24 цагийн цэцэрлэгт үе шаттай хамруулах, тэдэнд боловсрол, эрүүл мэнд, хамгааллын цогц үйлчилгээ үзүүлэхэд хэрэгжилтэд дэмжлэг үзүүлнэ.	Хамрагдалтын хувь	32 цэцэрлэгийн 72 бүлэгт 2055 хүүхэд хамрагдаж байна.	10 бүлэгт 250 хүүхдийг хамруулсан байна.	Улсын хэмжээнд цогц дэмжлэг шаардлагатай 2-5 хүртэлх насны 9328 хүүхэд байна. 2023-2024 оны хичээлийн жилд боловсролыг дэмжих үйлчилгээнд 9163 хүүхдийг хамруулж байгаа ба үүнээс хамгаалал, дэмжлэг зайлшгүй шаардлагатай зорилтот бүлгийн өрхийн 2055 хүүхдийг 24 цагийн үйл ажиллагаатай 32 цэцэрлэгийн 72 бүлэгт хамруулж хамран сургалт 2022-2023 оны хичээлийн жилээс 0,8 хувиар өссөн үзүүлэлттэй байна. 2023 оны 12 дугаар сард БШУ-	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					ы сайдын А/569 дүгээр тушаалаар батлагдсан “Цэцэрлэгийн үлгэрчилсэн дүрэм” - д 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэг, бүлгийн хүүхдийн бүртгэл, элсэлтийг зохион байгуулах, сургалт, үйл ажиллагааны зохион байгуулалт, хүүхэд хамгааллын асуудлыг тусгалаа. Ингэснээр 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэг, бүлгийн сургалтын чанарт ахиц гарч, зайлшгүй хамгаалал, дэмжлэг шаардлагатай хүүхдүүд сургуулийн өмнөх боловсролд хамрагдах эрх зүйн орчин бүрдэж байна. Нийслэлийн хэмжээнд 2023-2024 оны хичээлийн жилд 24 цагийн цэцэрлэгт 48 бүлгийн 1399 хүүхдийг сургуулийн өмнөх боловсролд хамруулж, боловсрол эрүүл мэндийн цогц үйлчилгээг үзүүлж байна. 2020 онд 31 бүлэгт 2055, 2021, онд 79 бүлэгт 1496 хүүхэд (КОВИД19-ийн үед буурсан), 2023, 2024 онд 72 бүлэгт 2055 хүүхэд хамрагдаж байна. . Боловсрол, шинжлэх		
--	--	--	--	--	--	--	--

					ухааны яамны зүгээс 24 цагийн үйл ажиллагаатай цэцэрлэг, бүлгийн тоог нэмэгдүүлэхээс илүүтэйгээр зайлшгүй хамгаалал, дэмжлэг шаардлагатай өрхийн хүүхдийг уян хатан нөхцөлтэйгөөр элсүүлэх, хамрагдаж буй хүүхдүүдэд тодорхой хугацаагаар хамгаалал, дэмжлэгийн үйлчилгээг үзүүлж, богиносгосон цагийн сургалтад үргэлжлүүлэн хамруулах зарчим барьж ажиллаж байна.		
12	Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд оршин суугаа газартаа цэцэрлэгт тэгш хамрагдах орчин нөхцөлийг бүрдүүлэхэд хэрэгжилт, зохион байгуулалтад дэмжлэг үзүүлнэ.	Цэцэрлэгийн тоо	Тусгай болон туслах нэмэлт хэрэглэгдэхүүнээр 80 цэцэрлэгийг хангасан.	-	Сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй 3119 хүүхэд байгаа ба 2023-2024 оны хичээлийн жилд 1977 хүүхэд цэцэрлэгт хамрагдаж, хамран сургалт 63.3 хувь болж, өмнөх хичээлийн жилээс 479 хүүхдийг нэмж хамруулаад байна. Мөн шинэ хичээлийн жилийн бэлтгэл хангах ажлын хүрээнд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дэлгэрэнгүйг судалгааг шинэчлэх, цэцэрлэгт хамрагдахгүй байгаа хүүхдийг илрүүлэх зорилгоор Сургуулийн өмнөх боловсролын	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					хэлтсийн даргын 2024.05.06-ны өдрийн "Мэдээлэл ирүүлэх тухай" албан бичгийг аймаг, нийслэлийн Боловсрол, шинжлэх ухааны газар/Боловсролын газарт хүргүүлээ. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн дэлгэрэнгүй судалгаагаагаар хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг цэцэрлэгт шинээр нэмж хамруулах нөхцөл боломжийг тодорхойлж, хамран сургалтыг нэмэгдүүлэх боломжтой. Үүнд: i) цэцэрлэгт хамрагдаж байгаа хүүхэд ii) шинэ хичээлийн жилд хамруулахаар төлөвлөж байгаа хүүхэд iii) Хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг хүлээн авах цэцэрлэг, бүлгийг аймаг, сум, дүүргээр нарийвчлан гаргах боломжтой. Үндэсний статистикийн хороотой хамтран 2023 оны Хүн амын тоон мэдээллээс сургуулийн өмнөх насны хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийн тоон судалгааг авч харьцуулалт хийнэ ажиллаж байна. (Хавсралт файлын код	
--	--	--	--	--	--	--

					0503) Ердийн хүүхдийн дунд хөгжлийн бэрхшээлтэй хүүхдийг сургуулийн өмнөх боловсролын үйлчилгээнд хамруулж буй 41 цэцэрлэгт хүүхдийн хөгжлийг дэжмих тохируулгат орчин бүүрдүүлэх зорилгоор 60,6 сая гаруй төгрөгийн тусгай болон нэмэлт хэрэглэгдэхүүнийг нийлүүллээ. Хавсралт: 3 файл		
3.4. Төрийн жинхэнэ албан хаагчийн нийтлэг үүргийг хэрэгжүүлж ажиллах							
13	ТАХ-ийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулах, төлөвлөгөөний биелэлт, бодлогын баримт бичиг, хууль тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилт, шаардлагатай бусад тоо баримт, мэдээллийг тогтоосон хугацаанд нь гаргаж, холбогдох нэгж, албан тушаалтанд хүргүүлэх	-	-	-	Нэгжийн гүйцэтгэлийн төлөвлөгөө болон бодлогын баримт бичиг, хууль тогтоомжийн хэрэгжилтийн сарын тайланг хугацаанд гаргаж тайлагналаа. Мөн хэлтсийн дарга болон бусад холбогдох газар, хэлтсийн дарга, мэргэжилтүүдэд өөрийн хариуцаж буй чиг үүргийн хүрээнд шаардлагатай болон цаг үеийн мэдээлэл, сургуулийн өмнөх боловсролын хүртээмж, хамран сургалтын хувь хэмжээ зэрэг статистик тоон мэдээллээр ханган	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%

					ажиллалаа. Нийслэлийн Сонгинохайрхан дүүрэгт байрлаж, сургуулийн өмнөх боловсролын сургалт, үйл ажиллагаа эрхлэн явуулж буй гадаадын хөрөнгө оруулалттай “Хүүхдийн баясгалан”, “Баянхошуу сейнтпоул” цэцэрлэгийн сургалт, үйл ажиллагаа, сургалтын орчны стандарт шаардлага хангаж буй байдалтай танилцаад, өөрийн хариуж буй ажлын чиг үүргийн хүрээнд цэцэрлэгийн хүчин чадал, нэг хүүхдэд ноогдох талбайн хэмжээ, сургуулийн өмнөх боловсролын сургалтын байгууллагын гадна, дотно орчин, хүүхэд хамгаалал, аюулгүй байдлын талаар зөвлөмжийг боловсруулж, хэлтсийн мэрэгжилтэнүүдтэй хамтран ажиллалаа.		
14	Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хууль, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай хууль,	-	-	-	Сургуулийн өмнөх боловсролын салбарын хүрээнд иргэн, байгуулагаас 2024 оны 06 дугаар сарын 1-ний өдрийн байдлаар ирүүлсэн 19 албан бичгийг шийдвэрлэж, 22	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100% Нэгжийн

	Хөдөлмөрийн тухай хууль, Авлигын эсрэг хууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон эдгээртэй нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийг хэрэгжүүлэх				албан бичгийг хүргүүлж, иргэний 2 гомдлыг шийдвэрлэн ажиллалаа. Хариуцсан албан чиг үүргийн хүрээнд архивын ХХНЖ-д заасан нэгж, 2 гарын авлага /ном/-ыг архивчид хүлээлгэн өглөө.	сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	даргын үнэлгээ төлөвлөсөн хугацаандаа гүйцэтгэсэн байдал: 100%
--	---	--	--	--	---	-----------------------------------	--

НЭМЭЛТ АЖЛЫН БИЕЛЭЛТ

№	Үүрэг даалгавар	Өгсөн субъект	Биелэлт
1	2	3	4

ХОЁР. МЭДЛЭГ ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

№	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин / биелэлт	Эхэлсэн, дууссан хугаца	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
4.1. Төрийн албаны тухай хууль, салбарын хууль, дагалдан гарсан хууль тогтоомжид заасан мэдлэг чадварыг эзэмших, тасралтгүй хөгжүүлэх							
1	Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль, дагалдаж гарах дүрэм журмыг	Холбогдох хууль, тогтоомж болон Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай	-	-	Боловсролын ерөнхий хууль, Сургуулийн өмнөх болон ерөнхий боловсролын тухай хууль болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн баримт бичгийг уншиж,	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%

	уншиж судлах, хуулийг хэрэгжүүлж ажиллана.	хуулийг уншиж судлан, хуулийн хэрэгжилтийг хангаж ажиллана.			судлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.	р сар, 12-р сар	
2	Төрийн захиргааны Ахлах түшмэлийн зэрэг дэвийн шалтгалтад бэлтгэх, зэрэг ахиулах.	-	Дэс түшмэл буюу Ахлах мэргэжилтэн	-	“Төрийн албаны шалгалт өгөх болзол болон шатлан дэвшүүлэх, сонгон шалгаруулах журам”-д заасан болзол ханган, Төрийн албаны шалгалтад орж, Төрийн захиргааны албан тушаалын ангилал Дэс түшмэлийн (Шинжээч)-ийн зэрэглэл олгох шалгалтад орж, 73,40 оноотой үнэлгээ авсан.	1-р сар, 2-р сар, 3-р сар, 4-р сар, 5-р сар, 6-р сар, 7-р сар, 8-р сар, 9-р сар, 10-р сар, 11-р сар, 12-р сар	Өөрийн үнэлгээ: 100% Нэгжийн даргын үнэлгээ: 100%
3	Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтад хамрагдана.	Худалдан авах ажиллагааны АЗ сертификатын хичээлийг бие даан судалж, цахим сургалтад хамрагдана.	-	Худалдан авах ажиллагааны АЗ сертификат олгох сургалтын цахим сургалтад хамрагдана.	Боловсрол, шинжлэх ухааны яамны нийт албан хаагчдыг хамруулсан Худалдан авах ажиллагааны гэрчилгээ олгох 8 цагийн сургалтад танхимаар хамрагдаж, 2024.05.16-ны өдөр мэргэшсэн ажилтны /АЗ/-гэрчилгээ олгох цахим шалгалтад хамрагдаж, 33 оноо авч, босго оноонд хүрээгүй. Иймд 2024 ондоо багтаан дахин шалгалт өгөхөөр төлөвлөж байна.	4-р сар, 5-р сар, 6-р сар	Өөрийн үнэлгээ: 50% Нэгжийн даргын үнэлгээ: 50%

ТАЙЛАН ГАРГАСАН:

Тэгш хамран сургалт, хүүхдийн хөгжил хамгаалал, сургалтын орчны бодлогын удирдлага, зохицуулалт хариуцсан ахлах мэргэжилтэн,
Сөртөөн Пүрэвсайхан /...../ Огноо: